

Салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг сунгах

1. Үйл ажиллагаа явуулж буй салбар, төлөөлөгчийн газар нь зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө Гадаадын иргэн, харьяатын газарт гаргана.

2. Зөвшөөрлийг сунгуулахдаа дараах баримт бичгийг бүрдүүлэн, зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлтэд хавсаргана.

Бүрдүүлэх баримт бичиг		
№	Баримт бичиг	Шаардлага
1	Салбар, төлөөлөгчийн газрын хаягийн бүртгэлийн талаархи баг, хорооны Засаг даргын тодорхойлолт	Албан бичгээр
2	Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл	Албан бичгээр /эх хувь/
3	Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг бол холбогдох зөвшөөрлийн хуулбар	Албан бичгээр
4	Үйл ажиллагааны тайлан	Гадаадын иргэн, харьяатын газрын хариуцсан мэргэжилтэнд и-мэйл хаягаар, албан бичгээр хүргүүлэх.
5	Хамтран ажилладаг байгууллагын тодорхойлолт	Албан бичгээр
6	Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн мэдээлэл, гэрээ, хэлэлцээр, санамж бичиг болон түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар	Албан бичгээр
7	Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Албан бичгээр

3. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийн хугацааг дараах нөхцөл, шаардлагыг харгалзан **5 /тав/** хүртэл жилээр сунгана.

- Засгийн газар хооронд хамтран ажиллах гэрээ байгуулсан;
- Монгол Улсад 10 /арван/ жилээс доошгүй хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан;
- Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт;
- Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн цар хүрээ;
- Ажлын байр бий болгосон байдал.

4. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийн хугацааг дараах нөхцөл, шаардлагыг харгалзан **3 /гурав/** хүртэл жилээр сунгана.

- Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт;
- Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн цар хүрээ;
- Ажлын байр бий болгосон байдал.

5.

№	Банк	Дансны дугаар	Улсын тэмдэгтийн хураамж	Гэрчилгээ шинээр авах
1	Голомт банк	1320000052	360.000 төгрөг	60,000 төгрөг

- Төлбөр төлсөн баримтыг хавсаргах